

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ОБЪЕКТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангаж, осол, зөрчилгүй байх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох (цаашид “гэрчилгээжүүлэх” гэх) үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Энэхүү журамд хэрэглэх нэр томъёо, тодорхойлолтыг Төмөр замын тээврийн тухай хууль, үндэсний стандартад заасан утгаар ойлгоно.

1.3.Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ эрхлэн гүйцэтгэнэ.

1.4.Гэрчилгээ нь тухайн объект, үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангасан болохыг нотолсон баримт бичиг бөгөөд үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахгүй.

1.5.Төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээ бүхий этгээдтэй хамтран ажиллах үндэслэл болох бөгөөд төмөр замын тээвэрлэлтийн болон суурь бүтцийн үйлчилгээ үзүүлнэ.

1.6.Гэрчилгээ хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явцыг гэрчилгээ хүсэгч, эзэмшигчид цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байна.

ХОЁР. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ОБЪЕКТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ХУГАЦАА

2.1.Объектын гэрчилгээ:

2.1.1.салбар зам;

2.1.2.хөдлөх бүрэлдэхүүн.

2.2.үйл ажиллагааны гэрчилгээ:

2.2.1.тээвэр зуучийн үйл ажиллагаа.

2.3.Гэрчилгээний хүчинтэй хугацаа:

2.3.1.объектын гэрчилгээг 3 жилийн хугацаагаар олгоно.

2.3.2.үйл ажиллагааны гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгоно.

2.4.Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах:

2.4.1.салбар замын объектын гэрчилгээг зураг төсөл, техникийн болон аюулгүй байдлыг хангасан эсэхийг харгалзан 3 хүртэлх жилийн хугацаагаар сунгана.

2.4.2.хөдлөх бүрэлдэхүүний объектын гэрчилгээг үйлдвэрлэгчээс тогтоосон эсхүл холбогдох стандартад заасан ашиглалтын болон их засварт орох хугацааг харгалзан 3 хүртэлх жилийн хугацаагаар сунгана.

2.4.3.үйл ажиллагааны гэрчилгээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны тайланг үндэслэн 5 хүртэлх жилийн хугацаагаар сунгана.

2.5.Гэрчилгээ нь олгосон эсхүл сунгасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж хугацаа дууссанаар хүчингүйд тооцно.

2.6.Гэрчилгээг цахимаар олгох бөгөөд QR кодоор баталгаажсан байна.

ГУРАВ.ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1.Хүсэлт гаргагчийн ирүүлсэн баримт бичгийн бүрдлийг холбогдох төрийн байгууллага, цахим системийн мэдээлэлд үндэслэн гэрчилгээг олгох, сунгах боломжтой эсэх дүгнэлт гаргах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагаас томилогдсон Ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ ажиллана.

3.2.Ажлын хэсэг нь Ажлын хэсгийн дарга, нарийн бичиг, холбогдох мэргэжилтнүүдээс бүрдсэн 7-оос ихгүй гишүүнтэй байх бөгөөд бүгд саналын эрхтэй байна.

3.3.Хүсэлтийг Ажлын хэсгийн нарийн бичиг хүлээн авч, ажлын 2 /хоёр/ хоногт багтаан баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангаагүй тохиолдолд буцаах, хангасан гэж үзвэл Ажлын хэсэгт шилжүүлнэ.

3.4.Ажлын хэсгийн гишүүд ажлын 5 /тав/ хоногт багтаан баримт материалыг магадлан шалгаж, татгалзсан эсхүл дэмжсэн саналаа цахим системд оруулна. Татгалзсан тохиолдолд үндэслэл бүхий саналаа тусгасан байна.

3.5.Гишүүдийн саналыг нэгтгэн, дийлэнх олонхийн саналаар гэрчилгээг олгох, сунгах боломжтой эсэх дүгнэлт гаргана.

3.6.Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн гэрчилгээ олгох, сунгах тухай төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

3.7.Шийдвэрийг үндэслэн гэрчилгээ олгоно.

3.8.Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сангийн бүртгэл хөтлөнө.

3.9.Гэрчилгээ хүссэн хүсэлтийг хүлээн авах, хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагаа нь ажлын 15 өдрөөс хэтрэхгүй байна.

3.10.Магадлан шалгах ажиллагаанд төрийн болон мэргэжлийн байгууллагаас дүгнэлт, тодорхойлолт гаргуулах, Ажлын хэсэг, эсхүл төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч /цаашид “улсын байцаагч” гэх/ гэрчилгээжүүлэх объектын бодит байдалд үзлэг, шалгалт хийх шаардлагатай бол энэхүү журмын 3.9-д заасан хугацааг нэг удаа ажлын таван өдрөөр сунгаж болно.

3.11.Магадлан шалгах ажиллагааны зардлыг тухайн хүсэлт гаргагч хариуцна.

ДӨРӨВ. ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, СУНГАХ

4.1.Объектын гэрчилгээ олгоход дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

4.1.1.хүсэлт;

4.1.2.улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар;

4.1.3.гэрчилгээжүүлэх объектын өмчлөл, эзэмшлийг нотолсон баримт бичиг (газар эзэмших, ашиглах гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг);

4.1.4.салбар замын хувийн хэргийн мэдээлэл (гүйцэтгэлийн зураг, техникийн паспорт, хиймэл төрөөрөмжийн зураг, ашиглалтад оруулсан дүгнэлт, засвар арчлалтын гэрээ, техникийн иж бүрэн үзлэгийн акт);

4.2.Үйл ажиллагааны гэрчилгээ олгоход энэхүү журмын 4.1.1, 4.1.2-т зааснаас гадна тээвэр, логистикийн мэргэжилтэй үндсэн ажилтны мэдээллийг ирүүлнэ.

4.3.Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд нь эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тогтворжуулах гэрчилгээг хавсаргасан байна.

4.4.Гэрчилгээ сунгахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

4.4.1.хүсэлт;

4.4.2.тухайн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны тайлан;

4.4.3.энэхүү журмын 4.2-т заасан мэдээлэл.

4.5.Гэрчилгээний хугацаа сунгах тухай хүсэлтийг гэрчилгээний хугацаа дуусахаас 21 хоногийн өмнө гаргаж, төрийн захиргааны байгууллага хугацаа сунгах эсэх асуудлыг ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэнэ.

ТАВ.ГЭРЧИЛГЭЭГ ТҮТГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, НӨХӨН ОЛГОХ

5.1. Гэрчилгээг дараах тохиолдолд улсын байцаагчийн актаар гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

5.1.1.гэрчилгээ эзэмшигч хүсэлт гаргасан;

5.1.2.гэрчилгээ эзэмшигчийн хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, байгууллага хохирсон, эрх ашиг зөрчигдсөн;

5.1.3.үл хөдлөх хөрөнгийн маргаантай;

5.1.4.зөрчилтэй, зөрчлөө арилгах хүртэл хугацаанд

5.1.5.гэрчилгээний нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон;

5.2.Улсын байцаагч энэ журмын 5.1-д заасан үндэслэл байгаа тухай гэрчилгээ эзэмшигчид урьдчилан мэдэгдэж, мэдэгдлийг хүргүүлсэн он, сар, өдрийг тэмдэглэлд тусгана.

5.3.Энэ журмын 5.2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш гэрчилгээ эзэмшигч ажлын 5 өдрийн дотор гэрчилгээг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, холбогдох баримт бичгийг эрх бүхий этгээдэд ирүүлээгүй бол гэрчилгээг түдгэлзүүлнэ.

5.4.Улсын байцаагч гэрчилгээг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар гэрчилгээ эзэмшигчид ажлын хоёр өдрийн дотор бичгээр, цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

5.5.Улсын байцаагчийн актаар энэ журмын 5.1-д заасан үндэслэл, нөхцөл, шаардлага арилсан тохиолдолд гэрчилгээ эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн гэрчилгээг сэргээнэ.

5.6.Гэрчилгээг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

5.6.1.гэрчилгээ эзэмшигч хүсэлт гаргасан;

5.6.2.гэрчилгээг авахдаа баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон;

5.6.3.эрх бүхий байгууллагаас үйл ажиллагааг зогсоосон тухай мэдэгдэл ирүүлсэн;

5.6.4.улсын байцаагчийн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлөө хоёр буюу түүнээс дээш удаа арилгаагүй тохиолдолд;

5.6.5.гэрчилгээг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, гэрчилгээг сэргээлгэх тухай хүсэлтээ ирүүлээгүй;

5.7.Гэрчилгээг дараах тохиолдолд гэрчилгээний хүчинтэй хугацаагаар нөхөн олгоно:

5.7.1.өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигчийн хүн, хуулийн этгээд солигдсон;

5.7.2.гэрчилгээжүүлсэн салбар замын дээд бүтэц, түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд, замын уртад болон хөдлөх бүрэлдэхүүний хийц, бүтээц, эд ангид өөрчлөлт орсон.

ЗУРГАА. ГЭРЧИЛГЭЭ ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРЭГ

6.1.Хүн, хуулийн этгээд нь өөрийн эзэмшлийн төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектыг гэрчилгээжүүлэлтэд заавал хамруулна.

6.2.Гэрчилгээний хүчинтэй хугацаанд объектын хэвийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж болох салбар замын дээд бүтэц, түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд, замын уртад болон хөдлөх бүрэлдэхүүний хийц, бүтээц, эд ангид өөрчлөлт оруулах тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь 30 хоногийн дотор энэ тухай төрийн захиргааны байгууллагад мэдэгдсэн байна.

6.3.Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, норм норматив, стандартыг дагаж мөрдөнө.

6.4.Гэрчилгээ эзэмшигч нь зөвхөн гэрчилгээнд заасан үйл ажиллагааг эрхэлнэ.

6.5.Үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхгүй.

ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙН САН

7.1.Энэхүү журамд заасан гэрчилгээ хүссэн болон сунгуулах хүсэлтийг хүлээн авах, хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явц болон гэрчилгээ олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан гэрчилгээний бүртгэл, мэдээллийн сантай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна.

7.2.Мэдээллийн санд төвлөрсөн мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглах үйл ажиллагааг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулиар зохицуулна.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1.Энэхүү журмыг зөрчсөн буруутай этгээдэд Зөрчлийн тухай хууль эсвэл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2.Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээгүй иргэн, хуулийн этгээдийг тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцуулсан албан тушаалтанд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---